

**ХОВД ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ШИЙДВЭР, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

/2017 оны 01 сарын 13-ны өдрийн хурал/

- Биологийн тэнхимийн эрхлэгч Б.Ганчимэгийг чөлөөлж, Д.Дарьхандыг тэнхимийн эрхлэгчээр томилон ажиллуулахаар шийдвэрлэв.
- “Нийгэм, эдийн засгийн судалгааны төв”-д албан бичиг төлөвлөн явуулахаар тогтов.
- Б.Дорж /СХУСС-ын тэнхимийн багш/ докторантурын сургалтад хамрагдах тул 01 сарын 16-ны өдрөөс 27-ны хооронд цалинтай чөлөө, Улаанбаатар-явж ирэх унааны зардал олгох
- ХИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөний төсөлтэй захиргааны зөвлөлийн гишүүд уншиж танилцан саналаа өгөх, 1/20-ны өдөр захиргааны зөвлөлийн гишүүд, стратеги төлөвлөгөө боловсруулах багийн гишүүдтэй уулзах
- Маркетингийн төлөвлөгөөг дараагийн захиргааны зөвлөлийн хурлаар эцэслэн боловсруулж оруулахыг Б.Энхжаргал /ГХХАА эрхэлсэн дэд захирал/, Б.Цэрэндаваа /НХУС-ын захирал/ нарт даалгав.
- ХИС-ийн цалинд Дотоод аудитын шалгалт хийсэнтэй холбогдуулан дотоод аудитын шалгалтын мөрөөр ажиллах төлөвлөгөө гаргаж ажиллахыг Б.Дэлгэрцэцэг /Санхүүгийн албаны дарга/-г үүрэг болгов.
 - ХИС-ийн Лицей сургуулийн багш нарын цалин бодох аргачлалыг ХИС-ийн дотоод аудитор, Лицей сургуулийн багш нар, холбогдох дэд захирлууд хамтран хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн сайжруулахыг Д.Өрнөхдэлгэр /ССБЗ эрхэлсэн дэд захирал/, Б.Батмөнх /ЭЗХХ эрхэлсэн дэд захирал/, Б.Дэлгэрцэцэг /Санхүүгийн албаны дарга/ нар даалгав.
 - Сургалтын албаны ахлах мэргэжилтэн М.Төвжаргалыг Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн системд зөрчилтэй оюутнуудын мэдээллийг оруулах ажлаар Улаанбаатар хотруу томилолтоор явуулахаар шийдвэрлэв.
 - Алба, нэгж, бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирлууд 2017 оны төлөвлөгөөг сайжруулан боловсруулж оруулж ирэн нээлттэй хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжүүдийг тусгахаар шийдвэрлэв.
 - 2017 онд БСШУС-ын Сайдтай байгуулах Үр дүнгийн гэрээнд нийлүүлэх бүтээгдэхүүн гаргаж өгөхөөр болов.
 - Лицей сургуулийн сургалтын үйл ажиллагааг өргөтгөхтэй холбогдуулан Оюутны байрны 2 давхарт амьдарч байгаа ажилчдыг 2017 оны 6 дугаар сараар тасалбар болгон “Оюутны байр чөлөөлөх тухай” мэдэгдэл хүргүүлэхээр шийдвэрлэв.

Захиргааны зөвлөлийн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын чиглэлийг гаргасан:

**Б.Болормаа /Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн/
Ховд хот, 2017.01.13**